



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 06 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 06 дугаар хуралдааныг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар /2025-03-31/ ХХЗХ-ны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын гүйцэтгэл, санал дүгнэлтийн тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай ажлын хэсгийн санал дүгнэлтийн тухай (ОранжКом ХХК); Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Интернэтэд суурилсан олон улсын телефон ярианы үйлчилгээний угтвар дугаар олгох тухай тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 15 (Тогтоол №65-78, 2025-03-31) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай ажлын хэсгийн санал дүгнэлтийн тухай (ОранжКом ХХК); Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Интернэтэд суурилсан олон улсын телефон ярианы үйлчилгээний угтвар дугаар олгох тухай тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 15 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 15 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 65 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (МЦХ ХК: “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах”) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 66 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Өрнүүн арвижих трейд ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс- БНХАУ/) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12

- дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 68 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 10 хуулийн этгээдэд 10 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 69 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Эс Ти Би Эс ХХК: “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх”) сунгасан;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 70 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (ОРЧС ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс – АНУ/) сунгасан;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 71 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Медиа холдинг ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны үйлчилгээ эрхлэх”) сунгасан;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 72 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдийн 5 тусгай зөвшөөрлийг (Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) сунгасан;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.1, 1.3 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 73 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн (Ишилан ХХК; Бунадо ХХК) 2 тусгай зөвшөөрлийг 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Лха хөх тэнгэр ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 74 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Лха хөх тэнгэр ХХК: Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт “Тоон телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ”, Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах) хүчингүй болгосон;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 75 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Оранжком ХХК-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт

харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /яриа хот, хот хооронд-суурин/, 14200016 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;

- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 76 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 2 иргэн, хуулийн этгээдэд (Иргэн Ч.Болоргэрэл; Баян ундрал констракшн ХХК) 2 харилцаа холбооны сүлжээний дугаарыг шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 77 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн (Юнителком ХХК) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтыг 2 жилийн хугацаатай тус тус сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 78 тоот тогтоолыг баталж, 1 хуулийн этгээдэд (Онлайн нетворк ХХК: Интернэтэд суурилсан олон улсын телефон ярианы үйлчилгээнд ашиглах 1672 угтвар дугаарыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн тус компанийн “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” 14200017 тоот зөвшөөрлийн хүчинтэй хугацаагаар) интернэтэд суурилсан олон улсын телефон ярианы үйлчилгээнд ашиглах угтвар дугаарыг шинээр олгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-04-08